

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

6-р анги

А хувилбар

2024 оны ... сарын ...

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 20

Суралцагчийн нэр:

Анги..... бүлэг....

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
Хариулт сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоно.
Цэнхэр өнгийн үзгэн балаар гаргацтай цэвэр бичнэ.

Цасны горхи

Уулын энгэрээр бяцхан горхи үсрэн дүүлж урсав. Цэлмэгхэн тэнгэр түүний жирэлзсэн урсгалд тусжээ. Хаврын наран хөөсрөн урсах цовоо жаахан горхийг баясан харна.

- Ээ, ямар хурдан горхи вэ? Тэр үсрэн дүүлж байгааг нь хараач хэмээн зүггүй салхи шулганав.
- Би бүхнийг чадна. Яагаад гэвэл би чинь уулын горхи. Чулууг ч элээж, модыг ч бөхийлгөн урсгаж чадна аа хэмээн горхи дуу алдав.
- Ёо, ёо. Намайг битгий урсгаач. Би ээжээсээ төөрчихнө гэж сайрын бяцхан чулуу гуйв.
- Муу сайн чулуунууд юу юм. Би хүчтэй, би мундаг.

Халуун наранд уулын энгэрийн цас хайлаад дуусав. Аальгүй бяцхан горхи гэвч онгирон дуулсаар байв. “Би хүчтэй. Би ачтай. “Хүүе-Хаая”

Цасны горхинд аюул тулж ирснийг уулын горхи мэджээ. Цасны горхины урсгал уулын голд ч хүрч чадалгүй газарт шингэх байв. Уулын гол боргион дэлээ цацруулан, омголон хүлэг морин адил нэгэнтээ цовхрон урсгал нэмлээ. Савнаас хальсан уулын гол бяцхан салаагаараа цасны горхийг ээжийн гар шиг хөтлөн урсгалд оруулав.

Уулын гол намуухан урсана. Харин цасны горхи урсгалд ороод, өөрийн гайхалтай чадалтайг, мөн их голын хүмүүс болоод байгаль дэлхийг ундаалах хувь тавилантайгаа гайхаж байлаа.


Нэг. Сонгох даалгавар

1. Эхийн өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлээрэй.
 1. Уулын гол намуухан урсана.
 2. Цасны горхины урсгал уулын голд ч хүрч чадалгүй газарт шингэх байв.
 3. Хаврын наран хөөсрөн урсах цовоо жаахан горхийг баясан харна.
 4. Муу сайн чулуунууд юу юм. Би хүчтэй, би мундаг.

A. 4,3,1,2 B.3,4,2,1 C. 3,4,1,2 D.4,3,2,1
2. Дараах өгүүлбэрүүдээс эхийн гол санааг илэрхийлсэн нь аль вэ?
 - A. Харин цасны горхи урсгалд ороод, өөрийн гайхалтай чадалтайг... гайхаж байлаа.
 - B. Уулын гол боргион дэлээ цацруулан, омголон хүлэг морин адил нэгэнтээ цовхрон урсгал нэмлээ.

- C. Уулын энгэрээр бяцхан горхи үсрэн дүүлж урсав.
- D. Халуун наранд уулын энгэрийн цас хайлаад дуусав.

3. “Халуун наранд уулын энгэрийн цас хайлаад дуусав.” Энэ үед цасны горхинд юу тохиолдоод байсан бэ?
- A. Харин цасны горхи урсгалд ороод, өөрийн гайхалтай чадалтайг....гайхаж байлаа.
 - B. Аальгүй бяцхан горхи гэвч онгирон дуулсаар байв.
 - C. Чулууг ч элээж, модыг ч бөхийлгөн урсгаж чадна аа хэмээн горхи дуу алдав.
 - D. Цасны горхины урсгал уулын голд ч хүрч чадалгүй газарт шингэх байв.
4. Хүсэн гуйж буй өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
- A. Цэлмэгхэн тэнгэр түүний жирэлзсэн урсгалд тусжээ.
 - B. Тэр үсрэн дүүлж байгааг нь хараач.
 - C. Намайг битгий урсгаач.
 - D. Яагаад гэвэл би чинь уулын горхи.
5. “Тэр” хэмээх үгийг харьяалахын тийн ялгалаар зөв хувилгасныг олоорой.
- A. Тэрний
 - B. Тэрнийг
 - C. Тэрүүний
 - D. Түүний
6. Өгүүлбэрийг уншаад кирил бичигт буулгаарай. 5 оноо




7.




гэсэн үгэнд дагуулан бичих харьяалахын тийн ялгалын нөхцөлийг олоорой.


A.




B.



C.



D.



8. Үйлэнд өртөж байгаа юмыг заахын тийн ялгалаар хэлбэржүүлэн захирч байгаа үгийг ямар үйл үг гэдэг вэ?
- A. Эс тусах үйл үг
 - B. Үүсмэл үг
 - C. Тусах үйл үг
 - D. Үүсмэл биш үг
9. Эхийн сэдвийг ямар асуултаар илрүүлдэг вэ?
- A. Юуны тухай өгүүлж байна вэ?
 - B. Хэрхэн дүгнэсэн байна вэ?
 - C. Ямар сургамжтай санаатай байна вэ?

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

6-р анги

Б хувилбар

2024 оны ... сарын ...

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 20

Суралцагчийн нэр:

Анги..... бүлэг....

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
Хариулт сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоно.
Цэнхэр өнгийн үзгэн балаар гаргацтай цэвэр бичнэ.
Гэмшил

Би арван настай байсан юм. Манайх тэр үед Сэлбэ голын хөвөөнд зусаж, би тэр хавийн хүүхдүүдтэй жараахай хөөцөлдөн тоглож өнждөг байлаа. Тэгэхэд Алимаа гэдэг суга таягтай охин голын эрэг дээр суучаад л усанд чулуу шидэн бидний барих гэж байгаа жараахайг зориуд үргээн, тачигнатал инээнэ. Тэгэхээр нь бид таягийг нь авч зугтаана. Уурлуулна.

Тэгсээр байгаад бүр уйлуулчихна. Уйлчихаар нь бид аргадаж эхэлнэ. Алимаа эхэр татан уйлж, хумсаараа газар маажин удтал тайтгарах ч үгүй, босох ч үгүй суучихна. Бид элдвээр аргадаж, инээхгүй болохоор нь циркийн алиалагчийг дуурайн худал ойчиж, уйлж маяглахаар гэнэт өөрийн эрхгүй инээд алдан, алиалсан хүүхдийг таягаар цохино. Цаадах нь унан тусан худлаа ёолон, газар өнхрөхөөр сая санаа алдан тайтгардаг сан.


Нэг өдөр бид Алимааг уйлуулдгаараа уйлуулчав. Харин Алимаа бидний хэнийг ч, яаж ч алиалсан инээсэнгүй. Тэгэхээр нь бид Алимаад “Малгай дүүрэн эрвээхэй барьж өгөхөөр эрвээхэй хөөцөлдөн гүйлдэв. Эрвээхэй цэцгэн дээр суумагц наран талаас нь сэмээрхэн гэтэж очин, малгайгаараа даран авдаг сан. Барьсан эрвээхэйгээ Алимаад авчирч өгнө. Бид бараг цэцгийн бүх өнгөтэй ижил өнгийн эрвээхэйнүүд барьж, эрвээхэйнүүдээ хаана хатаах тухай маргалдаж байтал Алимаа гэнэт малгайтай эрвээхэйнүүдийг цөмийг нь дээш цацчихав.

Өнгө өнгийн эрвээхэй нэгэн мөчид агаарт цэцэг дэлгэрэх шиг алаглаж харагдсанаа зүг бүр тийшээ нисэлдэхэд бид дахиад л нэг нэг эрвээхэй хөөн хашхиралдан одов. Алимаа тээр хойно хоцорчихсон бидний хойноос дэгэнцэж харагдлаа. Бид нэг хэсэг барьсан юмгүй баахан гүйлдэж яваад эргэж ирэхэд, малгай дотор нэг улаан цоохор эрвээхэй үлдчихсэн байв. Түүнийг хэчнээн ч дээшээ шидсэн нисэхгүй. Харин харьж явахдаа би хурууныхаа өндгөнд улаан хүрэн будаг шиг юм наалдчихсан байхыг үзээд дотор палхийн “Энэ лав нөгөө нисээгүй эрвээхэйн далавчных л байх” гэж бодогдон оройжин зүрх минь удтал түг түг цохилж билээ. Тэр цагаас хойш хүмүүс бие биенийхээ жигүүрийг гэмтээчих болгонд сэтгэл минь эмзэглэн надаас болж Алимаа суга таягтай болсон мэт санагддаг юм.

Нэг. Сонгох даалгавар

1. Яагаад “Гэмшил” гэж нэрлэсэн бэ?
 - A. Малгай дүүрэн эрвээхэй барьсан учраас
 - B. Малгай дотор нэг улаан цоохор эрвээхэй үлдчихсэн
 - C. Алимааг уурлуулдаг байсан учраас
 - D. Надаас болж Алимаа суга таягтай болсон мэт санагддаг учраас
2. Эхийн сэдвийг олоорой.
 - A. Гэмшил ухаарлын тухай
 - B. Эрвээхэй барьсан тухай

- C. Оройжин айсан тухай
 D. Алимаа охины тухай
3. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 A. Сэлбэ голын хөвөөнд жараахай хөөцөлдөн тоглодог
 B. Алимааг инээлгэж, уурлуулж уйлуулж, аргаддаг байсан
 C. Дотор палхийн зүрх минь түг түг цохилно
 D. Сэтгэл минь эмзэглэж надаас болсон мэт санагддаг юм.
4. Үйл явдал хэзээ өрнөж байна вэ?
 A. Алимаа охиныг инээх үед
 B. Алимаа охиныг тайтгарах үед
 C. Алимаа охиныг уурлах үед
 D. Намайг арван настай байхад
5. “Тэр” хэмээх үгийг заахын тийн ялгалаар зөв хувилгасныг олоорой.
 A. Тэрний
 B. Тэрнийг
 C. Тэрүүний
 D. Түүнийг
6. Өгүүлбэрийг уншаад кирил бичигт буулгаарай. 5 о н о о



7. - гэсэн үгэнд дагуулан бичих харьяалахын тийн ялгалын нөхцөлийг олоорой.
 A. B. C. D.

8. Үйлэнд өртөж байгаа юмыг заахын тийн ялгалаар хэлбэржүүлэн захирч байгаа үгийг ямар үйл үг гэдэг вэ?

- B. Эс тусах үйл үг B. Үүсмэл үг C. Тусах үйл үг D. Үүсмэл биш үг

9. Эхийн сэдвийг ямар асуултаар илрүүлдэг вэ?

- A. Юуны тухай өгүүлж байна вэ?
 B. Хэрхэн дүгнэсэн байна вэ?
 C. Ямар сургамжтай санаатай байна вэ?
 D. Ямар зорилгоор бичсэн бэ?

10. Л. Одончимэдийн “Хүүхдийн бор” өгүүллэгт зуныг хэрхэн дүрсэлсэн байна вэ?

- A. Өтгөн манантай B. Сэрүүн жавартай C. Аагим халуун D. Усан бороотой

11. Үйл явдал нь зүүдэнд өрнөдөг зохиол аль вэ?

- A. Кейко Таний “Цасан онгоцны үлгэр”
 B. Оскар Уайлдын “Тосгоны овгор”
 C. П.Хорлоогийн “Алт мөнгө хоёр”

